



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/74

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Биеийн тамир спортын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах тухай журам”-ын 2 дугаар заалт, 2.1 дэх хэсэг, 2020 оны 47 дугаар тогтоол, 2021 оны “Спортын наадам хойшлуулах тухай” 268 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын бүх ард түмний спортын 15 дугаар наадам, Монголын оюутны спортын 5 дугаар наадам зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Т.Дэлгэрсайхан	- Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд:	Б.Даваадорж	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Г.Жавзанхорлоо	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын соёл урлаг, спорт, соён гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Ч.Багдал	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Ч. Сүхбаатар	- Биеийн тамир спортын газрын хэлтсийн дарга
	С.Ганхуяг	- Биеийн тамир спортын газрын хэлтсийн дарга - Сумдын Засаг дарга нар - Спортын холбоод
Нарийн бичгийн дарга:	Ч.Түмэндэмбэрэл	- Биеийн тамир спортын газрын дарга

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Т.Дэлгэрсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 0427

Zah A/74 Kh